



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/236.

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар баг, Ч.Эрдэнэ-очир-2 дугаар гудамж, 214 тоотод байрлах Гөлөгдоржийн Долгорсүрэнгийн (ЙП81071201) эзэмшлийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 515м² газрыг Дашдоржийн Даваадоржид (ИЙ74011516) зориулалтын дагуу 9 жил, 5 дугаар баг, Худалдаа-1 гудамж, 122 тоотод байрлах Цэдэндоржийн Гээпилмаагийн (ИЮ50091680) эзэмшлийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 294м² газрыг Ганхуягийн Бавууцэрэнд (ИМ89060215) зориулалтын дагуу 11 жилийн хугацаатайгаар тус тус газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/257 дугаар захирамжийн хавсралтын Г.Долгорсүрэнтэй холбогдох заалт, 2022 оны А/90 дүгээр захирамжийн хавсралтын Г.Долгорсүрэнтэй холбогдох заалт, 2020 оны А/108 дугаар захирамжийн Ц.Гээпилмаатай холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0509